МЭДЭЭ · 2026 оны 6-р сарын 18

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас Бүгд Найрамдах Итали Улсын Турин хот дахь Нэгдсэн Үндэстний байгууллагын сургалтын төвд зохион байгуулсан "Олон Улсын хөдөлмөрийн хэм хэмжээ" сэдэвт сургалтад Прокурорын байгууллагын төлөөлөл оролцлоо.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас тодорхойлсон хөдөлмөрийн хүрээний суурь эрх ба үндсэн зарчмыг тусгасан конвенциудын хэрэгжилтийг хангах хүрээнд оролцогчдыг чадавхжуулах зорилготой тус сургалтад Ази, Африкийн 24 улсын 60 гаруй төлөөлөгч хамрагджээ.



Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн хамгаалах, гэрээ, конвенцыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил шийдвэр гаргах түвшинд хэрэглэх, хэрэгцээ шаардлагын хүрээнд тус сургалт нь цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой болсон байна.



Дашрамд дурдахад, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага нь НҮБ-ын хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрөлжсөн агентлаг бөгөөд дэлхийн 40 гаруй оронд байрлах

төлөөлөгчийн газруудаараа дамжуулан техникийн зөвлөгөө, дэмжлэгийг гишүүн орнуудад үзүүлдэг юм.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/151